



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 488

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах болон журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журам боловсруулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД  Т. МӨНХСАЙХАН



Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 сарын 18 өдрийн 4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга

Нарийн бичиг:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын Анагаах ухааны технологи, инноваци хэлтсийн Эрүүл мэндийн шинэ технологи, инноваци хариуцсан ахлах шинжээч

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Захиргаа,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Захиргаа,
төлөвлөлтийн хэлтсийн эмнэлгийн тусгай
зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нар

Эрүүл мэндийн сайдын 2025
оны 03 сарын 12 өдрийн 411 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2024 оны 7 дугаар сарын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох “Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/383 дугаар тушаал, “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн А/402 дугаар тушаал, “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/123 дугаар тушаал, “Журам шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/100 дугаар тушаал, “Шалгуур үзүүлэлт батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А/203 дугаар тушаал, “Шалгуур, дүгнэх аргачлал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/17 дугаар тушаал, “Шалгуур батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/264 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосонтой холбогдуулан Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Хоёр. Зорилго.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Гурав. Зорилт.

- 3.1. Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах;
- 3.2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох журмыг шинэчлэн боловсруулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх ажил.

- 4.1. Зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай хууль болон Эрүүл мэндийн сайдын тушаалын уялдах болон зөрчилдөх зүйл заалтыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх.
- 4.2. Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах.

4.3. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох журамд санал авах.

4.4. Тушаалын төслийг бэлтгэж, батлуулах.

4.5. Батлагдсан журмыг аймаг нийслэлийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх.

Тав. Хугацаа. 2025.02.15-2025.06.15

Зургаа. Хүрэх үр дүн.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болсон байна.

--oOo--